



“ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ” ХК

Тендершалгаруулалтгэр
ээнийнэр:

**ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ ХАРЬЦУУЛАЛТЫН ТЕНДЕР**

Тендер шалгаруулалт
гэрээний дугаар:

ЭТТ/202001136

УЛААНБААТАР ХОТ
2020 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

“Эрдэнэс-Тавантолгой” ХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос Цэвэрлэгээний материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ЭТТ/202001136 дугаартай харьцуулалтын тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн саналыг 2020 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 11 цаг 00 минутаас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем болох www.tender.gov.mn хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2020 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 11 цаг 10 минутад “Эрдэнэс-Тавантолгой” ХК, Жигжиджав-8, Финанс төв, 5 давхрын хурлын өрөөнд нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж-8,
Финанс төв 5 давхар, 503 тоот, Улаанбаатар-15160,
Худалдан авалт, ханган нийлүүлэлтийн хэлтэс
Утас: 75055555-511**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.




Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. 2018, 2019 онуудад тус бүр 1-ээс доошгүй ижил төстэй / цэвэрлэгээний материал/ хийж гүйцэтгэсэн гэрээ, бараа хүлээлцэн акт, эсхүл гэрээ байгуулсан газрын тодорхойлолт ирүүлнэ. 2. Компанийн танилцуулга. 3. Компанийн гэрчилгээний хуулбар. 4. Татварын тодорхойлолт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn хаягаар нэвтэрч лавлагаа хэсгээс шалгана. тендер нээх өдрийн байдлаар өргүй байх. 5. Шүүхийн төрөлжсөн архивын газраас хариуцагчаар оролцож байгаагүй тухай тодорхойлолт ирүүлэх. /тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар/ 6. Тендерт шалгарсан тохиолдолд техникийн тодорхойлолтын шаардлага хангаагүй бараа нийлүүлбэл захиалагчийн саналаар гэрээг цуцлахад татгалзах зүйлгүй талаарх албан бичиг ирүүлэх 7. Тендерт шалгарсан тохиолдолд бараа нийлүүлэтийн хуваарийн дагуу тендерт санал болгосон хугацаандаа нийлүүлээгүй бол захиалагчийн саналаар гэрээг цуцлахад татгалзах зүйлгүй талаарх албан бичиг ирүүлэх 8. Мэргэжлийн хяналтын лабораторийн дүгнэлт 9. Нийлүүлэх барааны зураг, захиалагчийн техникийн тодорхойлолттой харьцуулсан техникийн тодорхойлолт 10. Барааны гарал үүслийг нотлох баримт бичиг 11. Үнийн саналаа жишиг маягт 4-ийн дагуу ирүүлнэ. 12. Бараа нийлүүлэлтийн хуваарийг баталгаажуулан ирүүлнэ.
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Хаяг: Цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр /pdf/-ээр илгээнэ.</p> <p>Огноо: 2020 оны 07 дугаар сарын 03-ны өдөр</p> <p>Цаг: 11 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджав-8, Финанс төв, Утас: +976-7505-5555-511</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 5 давхар 503 тоот</p> <p>Огноо: 2020 оны 07 дугаар сарын 03-ны өдөр</p> <p>Цаг: 11 цаг 10 минутад нээнэ.</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй</p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Бараа, ажил, үйлчилгээний нэр /сэлбэг, барааны дугаар/	Үзүүлэлт	Тоо хэмжээ	Зориулалт	Дүйцэхүйц барааны зураг
1	Комет 450гр	450гр	455 ш	Цэвэрлэгээ, үйлчилгээнд	
2	Нойлын ус өнгө оруулагч	Bref эсвэл түүнтэй дүйцэхүйц Боодолдоо 2 ш-тэй	690 боодол	Цэвэрлэгээ, үйлчилгээнд	
3	Эдийн саван	Popular-тай дүйцэхүйц	414 ш	Цэвэрлэгээ, үйлчилгээнд	
4	Резинэн нимгэн бээлий /шар/	Чанартай Размер M,L	207 ш	Цэвэрлэгээ, үйлчилгээнд	
5	Аяга таваг угаагч шингэн	TRIO-той дүйцэхүйц 500гр	276 ш	Цэвэрлэгээ, үйлчилгээнд	
6	Илгэн алчуур /Гайхмаараа-тай дүйцэхүйц	50см х50см	276 ш	Цэвэрлэгээ, үйлчилгээнд	
7	Цайруулах, ариутгах бодис	КАО BLEACH эсвэл түүнтэй дүйцэхүйц 1,5л	138 ш	Цэвэрлэгээ, үйлчилгээнд	
8	Угаалгын шингэн бодис /Хивс цэвэрлэгч/	Капля, Ваниш эсвэл түүнтэй дүйцэхүйц	966 ш	Цэвэрлэгээ, үйлчилгээнд	

9	ОО ариутгагч бодис	Jonhson, Утёнок эсвэл түүнтэй дүйцэхүйц	552 ш	Цэвэрлэгээ, үйлчилгээнд	
10	Агааржуулагч	Glade эсвэл түүнтэй дүйцэхүйц	414 ш	Цэвэрлэгээ, үйлчилгээнд	
11	Угаалгын нунтаг	Tide эсвэл түүнтэй дүйцэхүйц 3кг-аас багагүй	138 ш	Цэвэрлэгээ, үйлчилгээнд	
12	Пракет шал угаагч	Пракет шал угаагч Пронто эсвэл түүнтэй дүйцэхүйц 750гр	552 ш	Цэвэрлэгээ, үйлчилгээнд	
13	Шалны алчуур	Чанартай эдэлгээ сайтай, ус сайн авдаг алчуур	276 ш	Цэвэрлэгээ, үйлчилгээнд	
14	Угаалгын бээлийний дотор өмсдөг цагаан нимгэн даавуун бээлий	Даавуун материал	276 ш	Цэвэрлэгээ, үйлчилгээнд	
15	Шил арчигч шингэн	Allone эсвэл түүнтэй дүйцэхүйц 500мл	276 ш	Цэвэрлэгээ, үйлчилгээнд	
16	Гарын шингэн саван 4л	MILANA, Алое вера эсвэл түүнтэй дүйцэхүйц 4л	138 ш	Цэвэрлэгээ, үйлчилгээнд	
17	Хлормин	Хайрцгандаа 90-ээс доошгүй ширхэгтэй	138 ш	Цэвэрлэгээ, үйлчилгээнд	
18	Пролон аяга угаагч болон түүнтэй дүйцэхүйц	11см х 7см 11см х 4см	152 ш	Цэвэрлэгээ, үйлчилгээнд	

19	Автомат шал угаагчийн алчуур	Чанартай дугуй хэлбэртэй	138 ш	Цэвэрлэгээ, үйлчилгээнд	
21	Гарын шингэн саван 300 мл	Зориулалтын шингэн саван Protex түүнтэй дүйцэхүйц	276 ш	Цэвэрлэгээ, үйлчилгээнд	
22	Мебель өнгөлөгч	Шүршдэг Pronto түүнтэй дүйцэхүйц	276ш	Цэвэрлэгээ, үйлчилгээнд	

- 1. Стандарт:** Олон улсын стандартын шаардлагыг хангасан байх ба тухайн ариун цэвэр, цэвэрлэгээний бараа, материалын гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.
- 2. Баглаа, боодол:** Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолд тавих нөхцөлийг бүрэн хангасан, мөн Монгол улсын /MNS/ стандартыг хангасан байх. Баглаа боодол нь цаг уур, давс, барааны жин, ачих буулгах хэрэгсэл, шаардлагыг хангасан байна. Баглаа боодол тус бүр дээр тухайн барааны нэр, тоо ширхэг зэргийг бичиж тэмдэглэсэн байна.
- 3. Бараа хүргэх газар:** [Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджав-8, Финанс төв, Утас: +976-7505-5555-511]

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Техникийн тодорхойлолтод заасан нэршлээр	Техникийн тодорхойлолт од заасны дагуу	Техникийн тодорхойлолтын дагуу		Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджа в-8, Финанс төв	<i>Гэрээ 1 жилийн хугацаатай байх ба захиалсан тоо хэмжээг захиалагчийн гаргасан захиалгын гүйцэтгэлээр нийлүүлнэ</i>	<i>Гэрээ 1 жилийн хугацаатай Захиалагч захиалга өгсөнөөс хойш 10 хоногоос 1 жил</i>	

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [моо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан моо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. Техникийн тодорхойлолтын шаардлага хангасан барааг Захиалагч шалгаж хүлээн авна. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</p> <ul style="list-style-type: none">1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;2) барааны гарал үүслийн гэрчилгээ.3) Шинжилгээний бичиг баримт <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхэд захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | 5.1. Шаардлага хангаагүй барааг шинээр солих үүргийг хүлээнэ. |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | <p>7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:</p> <p>Урьдчилгаа төлбөр олгохгүй. Захиалагчийн гаргасан захиалгын дагуу нийлүүлж, гүйцэтгэлээр бараа хүлээлцэн акт, нийлүүлэгч талын нэхэмжлэлийг үндэслэн төлнө.</p> |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹ | <p>9.1. Алданги оногдуулах хувь: Гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн хоног тутамд 0,5 %</p> <p>Алдангийн нийт дүн: Биелүүлээгүй үүргийн үнийн дүнгийн 10%-иас хэтрэхгүй</p> |

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]